



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024 /250-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ц.Ундраа Утас: 70363047 Цахим хаяг: undraats@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН , ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4-10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11-15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18
5.1 Төлбөрийн акт	18
5.2 Албан шаардлага.....	18-19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХҮЕГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Л.ЗОРИГТБААТАР ТАНАА

2024.02.16 № САА-2024/250-НА-ТН-ТУЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн ХХҮГ нь тайланд онд ХХҮЕГ-аас хөрөнгө оруулалтаар 35,015.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас 82,712.7 мянган төгрөгийн, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас Старт Ап хөтөлбөрийн зардалд 33,000.0 мянган төгрөгийн, Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ахмадын сувиллын үйл ажиллагааны зардалд 10,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт 125,712.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 104,282.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Ахмадын сувиллын хүнсний төсөв хангалтгүй, харьцуулалтын аргаар зарласан сонгон шалгаруулалтад бэлтгэн нийлүүлэгчид материал ирүүлдэггүй, сонгон шалгаруулалтыг удаа дараа зарладаг зэргээс шалтгаалан үйл ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл учирч, тус газрын өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө жил дараалан тасарч байна.

Бусад асуудлын хэсэг

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 63 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг 98.7 хувьтай үнэлүүлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,685,813.00	25,195,563.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,685,813.00	25,195,563.00
35400	Хангамжийн материал	25,685,813.00	25,195,563.00
35410	Бичиг хэргийн материал	4,244,500.00	3,754,250.00
35420	Аж ахуйн материал	2,564,090.00	2,564,090.00
35450	Барилгын засварын материал	313,500.00	313,500.00
35470	Бусад хангамжийн материал	18,563,723.00	18,563,723.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,509,566,181.49	1,437,977,076.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,509,566,181.49	1,437,977,076.36
39200	Биет хөрөнгө	1,441,619,015.91	1,371,654,910.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,543,030,129.86	1,543,030,129.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(191,585,123.01)	(231,548,459.85)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	187,733,000.00	187,733,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(187,733,000.00)	(187,733,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	217,625,748.07	260,833,092.23
39206	Хуримтлагдсан элэгдэл	(167,738,903.44)	(228,274,600.04)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	134,299,617.00	130,125,911.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	(94,012,452.57)	(102,511,163.03)
39300	Биет бус хөрөнгө	67,947,165.58	66,322,165.54
39301	Программ хангамж	7,655,000.00	7,655,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,675,834.42)	(6,300,834.46)
39303	Бусад биет бус хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,535,251,994.49	1,463,172,639.36
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,535,251,994.49	1,463,172,639.36
51	Засгийн газрын хувь оролцоо	1,535,251,994.49	1,463,172,639.36
51100	Засгийн газрын оруулсан капитал	64,968,000.00	64,968,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	64,968,000.00	64,968,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	1,470,283,994.49	1,398,204,639.36
51210	Өмнөх үеийн үр дүн	1,534,605,343.35	1,470,283,994.49
51220	Тайлант үеийн үр дүн	(64,321,348.86)	(72,079,355.13)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,535,251,994.49	1,463,172,639.36

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,200,496,593.96	1,671,102,409.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	103,092,376.96	106,248,173.36
120	Нийтлэг татварын бус орлого	103,092,376.96	106,248,173.36

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,840,000.00	98,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,840,000.00	98,700,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,112,376.96	7,498,173.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,140,000.00	50,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,097,404,217.00	1,564,854,236.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,011,501,000.00	1,460,571,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,011,501,000.00	1,460,571,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,903,217.00	104,282,736.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,108,300.00	42,796,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,314,917.00	61,486,116.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,480,000.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,264,817,942.82	1,743,181,764.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,264,817,942.82	1,743,181,764.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,208,678,604.70	1,721,523,863.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,669,562.25	1,163,246,036.78
210101	Үндсэн цалин	529,220,150.22	645,927,023.99
210102	Нэмэгдэл	122,444,044.83	246,068,035.23
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,155,000.00	122,799,712.50
210104	Урамшуулал	60,850,367.20	148,451,265.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,306,985.63	148,875,488.27
210201	Тэтгэврийн даатгал	65,584,036.04	103,180,786.19
210202	Тэтгэмжийн даатгал	7,730,239.57	12,043,854.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,844,831.68	9,166,845.95
210204	Ажилгүйдлийн даатгал	1,377,079.88	2,279,011.53
210205	Эрүүл мэндийн даатгал	13,770,798.46	22,204,990.21
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,693,657.00	117,216,558.20
210301	Гэрэл, цахилгаан	7,791,914.00	8,604,748.20
210302	Түлш, халаалт	104,133,521.00	104,111,610.00
210303	Цэвэр, бохир ус	5,768,222.00	4,500,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,554,484.00	19,480,951.11
210401	Бичиг хэрэг	7,057,600.00	9,467,260.00
210402	Тээвэр, шатахуун	2,485,584.00	3,767,698.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,681,200.00	4,900,043.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	312,000.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,018,100.00	965,950.00
2105	Норматив зардал	37,107,535.00	41,061,620.00
210502	Хоол, хүнс	37,107,535.00	41,061,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,893,500.00	5,462,050.00
210604	Урсгал засвар	2,893,500.00	5,462,050.00
2107	Томилолт, зочны зардал	4,032,000.00	2,767,400.00
210702	Дотоод албан томилолт	4,032,000.00	2,767,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,620,455.00	99,904,730.13

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,717,133.00	98,853,681.13
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,750.00	261,865.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	520,000.00	606,000.00
210807	Газрын төлбөр	56,797.00	64,659.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	112,800,425.82	123,509,028.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,200,000.00	33,393,100.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		11,028,650.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,600,425.82	79,087,278.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,139,338.12	21,657,901.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,167,500.00	1,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,167,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,470,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,971,838.12	20,187,901.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,971,838.12	20,187,901.51
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(64,321,348.86)	(72,079,355.13)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(64,321,348.86)	(72,079,355.13)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,193,244,217.00	1,663,554,236.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	95,840,000.00	98,700,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	95,840,000.00	98,700,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	95,840,000.00	98,700,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	95,840,000.00	98,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,097,404,217.00	1,564,854,236.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,011,501,000.00	1,460,571,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,011,501,000.00	1,460,571,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,903,217.00	104,282,736.00
131103	ЗГНХ, ЗДН Хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,108,300.00	42,796,620.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,314,917.00	61,486,116.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,480,000.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,193,244,217.00	1,663,554,236.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,193,244,217.00	1,663,554,236.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,137,104,878.88	1,641,896,334.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	740,669,562.25	1,163,246,036.78
210101	Үндсэн цалин	526,392,650.22	642,371,297.99
210102	Нэмэгдэл	122,444,044.83	249,500,473.73
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,982,500.00	122,923,000.00

210104	Урамшуулал	60,850,367.20	148,451,265.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,306,985.63	148,875,488.27
210201	Тэтгэврийн даатгал	65,584,036.04	102,457,423.81
210202	Тэтгэмжийн даатгал	7,730,239.57	12,043,854.39
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,844,831.68	9,305,083.39
210204	Ажилгүйдлийн даатгал	1,377,079.88	2,279,011.53
210205	Эрүүл мэндийн даатгал	13,770,798.46	22,790,115.15
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,693,657.00	117,216,558.20
210301	Гэрэл, цахилгаан	7,791,914.00	8,604,718.20
210302	Түлш, халаалт	104,133,521.00	104,111,610.00
210303	Цэвэр, бохир ус	5,768,222.00	4,500,200
2104	Хангамж, бараа материалын зардал	15,421,884.00	18,820,701.11
210401	Бичиг хэрэг	7,115,250.00	8,745,850.00
210402	Тээвэр, шатахуун	2,485,584.00	3,767,698.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,681,200.00	4,962,303.11
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	312,000.00	380,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,827,850.00	964,850.00
2105	Норматив зардал	37,107,535.00	41,061,620.00
210502	Хоол, хүнс	37,107,535.00	41,061,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,144,500.00	5,462,050.00
210604	Урсгал засвар	3,144,500.00	5,462,050.00
2107	Томилолт, зочны зардал	4,032,000.00	2,767,400.00
210702	Дотоод албан томилолт	4,032,000.00	2,767,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,620,455.00	99,904,730.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	80,717,133.00	98,853,681.13
210803	Даатгалын үйлчилгээ	170,775.00	96,525.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,750.00	261,865.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	520,000.00	606,000.00
210807	Газрын төлбөр	56,797.00	64,659.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,108,300.00	44,541,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,108,300.00	33,000,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх		11,541,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,139,338.12	21,657,901.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,167,500.00	1,470,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,167,500.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,470,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,971,838.12	20,187,901.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,971,838.12	20,187,901.51
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0	
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	
2200	Дотоод эх үүсвэрээр	0	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0	
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/	
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	
1	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,534,605,343.35	1,599,573,343.35	
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,968,000.00	1,534,605,343.35	1,599,573,343.35	
9	Тайлант үеийн үр дүн	-	(64,321,348.86)	(64,321,348.86)	
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,470,283,994.49	1,535,251,994.49	
11	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,470,283,994.49	1,535,251,994.49	
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,968,000.00	1,470,283,994.49	1,535,251,994.49	
19	Тайлант үеийн үр дүн	-	(72,079,355.13)	(72,079,355.13)	
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,968,000.00	1,398,204,639.36	1,463,172,639.36	

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлан он		Хэмнэлт хэтрэлт	
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дүнгээр	Хувь
12	Татварын бус орлого	1,583,037,600.00	1,559,271,500.00	43,604,064.64	97.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,583,037,600.00	1,559,271,500.00	43,604,064.64	97.2
120010	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/	100,950,000.00	98,700,000.00	2,250,000.00	97.7
122005	Төсвөөс санхүүжих	1,482,087,600.00	1,460,571,500.00	41,354,064.64	97.2
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,583,037,600.00	1,539,083,598.49	43,953,701.51	97.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,583,037,600.00	1,539,083,598.49	43,953,701.51	97.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,583,037,600.00	1,539,083,598.49	43,953,701.51	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,178,373,300.00	1,163,246,336.78	15,126,963.22	99
210101	Үндсэн цалин	714,817,800.00	642,371,297.99	72,446,502.01	90
210102	Нэмэгдэл	395,688,100.00	249,500,773.73	146,187,326.27	63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,983,400.00	122,923,000.00	(95,939,600.00)	456

210104	Урамшуулал	40,884,000.00	148,451,265.06	(107,567,265.06)	363
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,955,800.00	148,875,488.27	80,311.73	
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	101,289,900.00	102,457,423.81	(1,167,523.81)	101
210202	Тэтгэмжийн даатгал	11,916,500.00	12,043,854.39	(127,354.39)	101
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,533,200.00	9,305,083.39	228,116.61	97.6
210204	Ажилгүйдлийн даатгал	2,383,300.00	2,279,011.53	104,288.47	96
210205	Эрүүл мэндийн даатгал	23,832,900.00	22,790,115.15	1,042,784.85	96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,476,600.00	117,216,558.20	4,260,041.80	96.4
210301	Гэрэл, цахилгаан	10,346,000.00	8,604,748.20	1,741,251.80	83
210302	Түлш, халаалт	104,077,600.00	104,111,610.00	(34,010.00)	100
210303	Цэвэр, бохир ус	7,053,000.00	4,500,200.00	2,552,800.00	64
2104	Хангамж, бараа материалын зардал	8,128,300.00	7,613,803.11	514,496.89	93.6
210401	Бичиг хэрэг	2,256,100.00	3,021,250.00	(765,150.00)	134
210402	Тээвэр, шатахуун	697,800.00	497,800.00	200,000.00	71
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,856,900.00	2,749,903.11	106,996.89	96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	307,200.00	380,000.00	(72,800.00)	124
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,010,300.00	964,850.00	1,045,450.00	48
2105	Норматив зардал	32,285,000.00	31,265,000.00	1,020,000.00	96.8
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	420,000.00		420,000.00	
210502	Хоол, хүнс	31,265,000.00	31,265,000.00		100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00		600,000.00	100
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,610,600.00	5,462,050.00	148,550.00	97.3
210601	Багаж, техник хэрэгсэл				
210604	Урсгал засвар	5,610,600.00	5,462,050.00	148,550.00	97
2107	Томилолт, зочны зардал	48,700.00		48,700.00	
210702	Дотоод албан томилолт	48,700.00		48,700.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	65,172,900.00	63,934,662.13	1,238,237.87	98

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,000,000.00	62,883,613.13	1,116,386.87	98
210803	Даатгалын үйлчилгээ	171,100.00	96,525.00	74,575.00	56
210804	Тээврийн хэрэгслийн татвар	262,000.00	261,865.00	135.00	100
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00	22,000.00	50
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	606,000.00	606,000.00		100
210807	Газрын төлбөр	89,800.00	64,659.00	25,141.00	72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,986,400.00	1,470,000.00	21,516,100.00	0.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,986,400.00	1,470,000.00	21,516,100.00	0.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,516,100.00		21,516,100.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,470,300.00	1,470,000.00	300.00	100
26	Төвлөрүүлэх шилжүүлэг				
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг				
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ					
БАЙГУУЛЛАГЫН ТОО					
	Төсвийн байгууллага	1	1	0	100
	Төсвөөс гадуур байгууллага	1	1	0	100
АЖИЛЛАГСДЫН ТОО					
	Удирдах ажилтан	63	63	0	100
	Гүйцэтгэх ажилтан	1	1	0	100
	Үйлчлэх ажилтан	51	51	0	100
	Гэрээт ажилтан	11	11	0	100
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ					
	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	63	63	0	100
	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	52	52	0	100
	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0	100

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,903,217.00	104,282,736.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,903,217.00	104,282,736.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,903,217.00	104,282,736.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,102,984.00	11,206,898.00
210401	Бичиг хэрэг	4,673,000.00	5,724,600.00
210402	Тээвэр, шатахуун	1,829,984.00	3,269,898.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	600,000.00	2,212,400.00

2105	Норматив зардал	6,867,535.00	9,796,620.00
210502	Хоол, хүнс	6,867,535.00	9,796,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	424,000.00	-
210604	Урсгал засвар	424,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	4,032,000.00	2,767,400.00
210702	Дотоод албан томилолт	4,032,000.00	2,767,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	24,368,398.00	35,970,068.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,368,398.00	35,970,068.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,108,300.00	44,541,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,108,300.00	33,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11,541,750.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	50,000,000.00	104,282,736.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(21,430,064.00)
300008	Гадаад орон, олон улсын байгууллага дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл	-	(21,430,064.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	50,000,000.00	125,712,800.00
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	3,000,000.00	43,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	47,000,000.00	82,712,800.00
12000	- Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар / цаашид ХХҮГ гэх / нь “Хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, нийгмийн халамжийн талаар төрөөс баримталж буй цогц бодлогыг орон нутагт чанартай, хүртээмжтэй, шуурхай, хүргэх замаар иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчныг бий болгож амьжиргааны түвшнийг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртээгчээс хөдөлмөр эрхлэгч болох нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг нэмэгдүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлт тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дугаар сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

ХХҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ХХҮЕГ-ын Захиргаа, аудитын хэлтсээс дотоод хяналт тавьдаг бөгөөд сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан төсвийн дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,079.3 мянган төгрөгөөр буюу 4.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	25,685.8	25,195.5	(490.2)
Үндсэн хөрөнгө	1,509,566.2	1,437,977.1	(71,589.1)
Нийт хөрөнгө	1,535,251.9	1,463,172.6	(72,079.3)
Засгийн газрын хувь оролцоо	1,535,251.9	1,463,172.6	(72,079.3)
/Эздийн өмч/			
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,535,251.9	1,463,172.6	(72,079.3)

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,437,977.1 мянган төгрөг болж 71,589.1 төгрөгөөр буурсан нь нь, ХХҮЕГ-аас 35,015.1 мянган төгрөгийн Ай пад Самсунг таблет, Мэргэжлийн хяналтын газраас 12,245.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж болон тавилга үнэ төлбөргүйгээр тус тус хүлээн авч, ТӨБЗГ-ын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 827 дугаар тогтоолоор 8,226.6 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, 79,087.3 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,463,172.6 мянган төгрөг болж 72,079.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,109,739.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 234,133.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 29,097.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,

- Бусад урсгал шилжүүлгийн зардлыг 470.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 24,714.1 мянган төгрөгөөр бууруулан,
- Хангамж бараа материалын зардлыг 6,746.8 мянган төгрөгөөр бууруулан,
- Норматив зардлыг 17,215.0 мянган төгрөгөөр бууруулан,
- эд хогшил, урсгал засварын зардлыг 8,734.7 мянган төгрөгөөр бууруулан,
- Томилолт, зочны зардлыг 1,748.3 мянган төгрөгөөр бууруулан,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 12,875.2 мянган төгрөгөөр бууруулсан зэрэг нийт **191,667.2** мянган төгрөгөөр нэмэгдүүлэн **1,301,406.2** мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн дундуур батлагдсан төсөвт тодотгол, зохицуулалт хийж 281,631.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 265,553.9 мянган төгрөгөөр,
- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 24,423.2 мянган төгрөгөөр,
- Хангамж бараа материалын зардлыг 5,128.6 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 4,350.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийг 148.8 мянган төгрөгөөр
- Бусад урсгал шилжүүлэг 17,675.6 мянган төгрөгөөр тус тус бууруулан **1,583,037.6** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,482,087.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 100,950.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,460,571.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 98,700.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт 1,559,271.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн, 1,539,083.6 мянган төгрөгийг зарцуулж, 20,187.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,539,083.6 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, тэтгэмж урамшууллын зардлыг хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/				
д/д	Хөтөлбөр,	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71902-Нийгмийн халамж	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	1,247,773.7	1,232,515.4	15,258.3	98.7
		80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	100,950.0	98,350.1	2,599.9	97.7
		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	22,986.4	1,470.0	21,516.4	63.9
2	72102-Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	211,327.5	206,748.1	4,579.4	97.8
Дүн			1,583,037.6	1,539,083.6	43,954.0	97.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн дансанд дараах 125,712.8 мянган төгрөгийг төвлөрүүлэн, 104,282.7 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, 21,430.1 мянган төгрөгийг ХХҮЕГ-т буцааж шилжүүлсэн байна. Үүнд:

- ХХҮЕГ-аас өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны дахин үнэлгээний санхүүжилт 7,000.0 мянган төгрөг,
- Амьжиргааг дэмжих зөвлөлийн улирлын урамшуулалд 32,647.0 мянган төгрөг,
- Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны ажлын зардалд 35,611.8 мянган төгрөг,
- ҮОМШӨ-ний улсын байцаагчийн хяналт шалгалтын зардалд 2,454.0 мянган төгрөг,
- Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтын зардалд 5,000.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас Старт Ап хөтөлбөрийн зардалд 33,000.0 мянган төгрөг,
- Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас ахмадын сувиллын үйл ажиллагааны зардалд 10,000.0 мянган төгрөг гэх мэт.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Ундраа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/30 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,264,817.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 12,648,2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд тус газрын батлагдсан төсөв материаллаг хэмжээгээр өөрчлөгдсөн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,743,181.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **17,431.8** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд тус газар нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 15,127.3 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 38.5 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 4,260.1 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 199.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 562.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Сэлэнгэ аймгийн ХХҮГ-ын мэдээлбэл зохих 28 төрлийн 159 мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 2 мэдээллийг мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон:

- Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт / 3, 4, 6, 8, 11 сар, 1 дүгээр улирлын мэдээлэл /,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт /3,4,6,8, 11 дүгээр саруудад/,
- Аудитын тайлан дүгнэлт зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан / 7 дугаар сар /

Огт мэдээлээгүй:

- Дараа жилийн төсвийн төсөл / 9 дүгээр сар /
- 2023 оны шилэн дансны улирлын тайланг 3,4 улиралд.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус газрын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 7,149.1 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй, өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан зэрэг 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0 үлдэгдэлтэй боловч ашиглагдаж байгаа хөрөнгийг бодит үнэ цэнээр нь дахин үнэлж бүртгээгүй, зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	7,149.1	1	7,149.1	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	3	7,149.1	2	7,149.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулсан алдаа:

Аудитаар Ахмадын сувиллын буюу өөрийн үйл ажиллагааны орлогын 750.0 мянга төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэсэн алдааг залруулав.

Зөрчил:

Аудитаар нийт 13,023.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 10,773.1 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоож, 2,250.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Албан хаагчдын 1,2 дугаар улирлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухайн үеийн үндсэн цалингаас бус 7 дугаар сарын цалингаас тооцож **10,773.1** мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг **2,250.0** мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс,

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

орон нутгийн төсөвт оруулах болон тухайн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өөрийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөж, төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өөрийн орлогыг данс буруу бүртгэсэн	1	750.0			1	750.0	1	750.0				
Дүн	1	750.0			1	750.0	1	750.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт-ны тоо	Тоо	Дүн
Өөрийн орлогын төлөвлөгөөг тасалсан	1	2,250.0			1	2,250.0						
Үр дүнгийн мөнгөн урамшууллыг илүү тооцож олгосон.	1	10,773.1	1	10,773.1								
Дүн	2	13,023.1	1	10,773.1	1	2,250.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	12						12	
Огт мэдээлээгүй	2						2	
Нийт дүн	14						14	